



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 11 дүгээр сарын 29 өдөр Дугаар 92

Хэрлэн сум

LXXXXII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 92 дугаар хуралдаан 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын хурлын танхимд 57,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Улсын Онцгой комиссын 2021 оны 29 дүгээр хуралдааны шийдвэрийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2.Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, дархлаажуулалтын мэдээллийг танилцуулах,

Эрүүл мэндийн газар

3.Ресторан, баар, кафе, караоке эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн цагийн хязгаарлалтыг цуцлах тухай хүсэлтийг танилцуулж аймгийн Онцгой комиссын 2021 оны 109 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах эсэх талаар хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4.Малын өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар


5.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн талаар мэдээлэл танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

1.1.Коронавируст халдвар "Ковид-19" халдварын шинэ мутаци хувилбар тархсан тухай Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зарласантай холбогдуулан урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтын ажлыг бүх шатны түвшинд эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах,

 / М.Бадамсүрэн
/ х/ч Б.Цогтбаяр

1.2. Дархлаажуулалтын ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулах,

1.3. Дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар сумын Эрүүл мэндийн төвүүдэд албан бичгээр чиглэл хүргүүлж хяналт тавьж ажиллах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин,
Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт:

1.4. Дархлаажуулалтын явуулын багийг ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.5. Дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар сумын Засаг дарга, Онцгой комисс дарга нарт албан бичгээр чиглэл хүргүүлэх,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн, Ш.Ёл,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.6. Олон нийтийн үзвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудаар үйлчлүүлж буй иргэдийн дархлаажуулалтын нэмэлт 3 дугаар тунд хамрагдсан байдалд хяналт тавьж ажиллах,

Хоёр. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1. Амны хаалтаа авч үйлчлүүлдэг баар, караоке, ресторан, хүнсний дэлгүүрийн үйл ажиллагааг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд 00:00 цаг хүртэл цагийн хязгаарыг сунгах талаар аймгийн Онцгой комиссын 2021 оны 109 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулж батлуулах,

Хэрлэн сүмийн Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,

Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,


Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

Цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

2.2. Үйлчилгээний газруудын цагийн хязгаарлалтыг сунгасантай холбогдуулан үйлчилгээний байгууллагуудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулах, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавих талаар баталгаа гаргуулах,

 / М.Бадамсүрэн
/ х/ч Б.Цогтбаяр

2.3. Үйлчилгээний байгууллагын ажилтан, ажиллагсдаас халдварт өртөж эдгэрсэн болон нэмэлт 3 дугаар тунд хамрагдаагүй тохиолдолд дархлаажуулалтад хамруулах, үйлчлүүлж буй иргэдийг дархлаажуулалтад хамрагдсан байх талаар шаардлага тавих, дархлаажуулалтад хамрагдаагүй бол шинжилгээ өгөх чиглэлээр шаардлага тавих,

Гурав. Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

3.1. Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд зөрчил гаргасан "Дорнын кроп" ХХК-д хуулийн хариуцлага тооцоход хяналт тавьж ажиллах,

3.2. Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хариуцлага тооцож ажиллах талаар сумдын Онцгой комисст чиглэл хүргүүлэх,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, Цагдаагийн хурандаа Т.Ганзориг-д:

3.3. Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хуулийн хариуцлага тооцож ажиллах,

АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

3.4. Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд зөрчил гаргасан аж ахуй нэгж, байгууллагад хуулийн хариуцлага тооцох тухай санал боловсруулж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулах,


Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа-д:

3.5. Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд зөрчил гаргахгүй байх талаар сумдын Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд албан бичгээр чиглэл хүргүүлэх,

3.6. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний үед сумдад томилогдож ажилласан ажлын хэсгүүдийн томилолт, шатахууны зардлыг тооцож аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга,
Онцгой комиссын гишүүн Э.Батболд,
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа нарт:

3.7. Зарим сумдад батлагдсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний талаар аймгийн Онцгой комиссын хуралдаанаас гарсан шийдвэрийг олон нийтэд бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх,


М.Бадамсүрэн
х/ч Б.Цогтбаяр

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын
дарга нарт:

3.8.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний улмаас мал, махны хөдөлгөөн түр хязгаарлалттай байсан сумд болох Баяндун, Гурванзагал, Дашбалбар, Сэргэлэн, Цагаан-Овоо, Хөлөнбуйр сумдын эрүүл бүсээс маханд малын эрүүл мэндийн гэрчилгээг олгох,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.1.Аймаг, сумдын хяналтын цэгүүдэд галын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны талаар хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж дүгнэлт гаргаж зөрчлийг арилгуулах,

4.2.Галын аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулж сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт зөвлөмж хүргүүлэх,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

4.3.Аймаг, сумын Онцгой комиссын шийдвэрээр томилогдон ажиллаж буй албан хаагч нарт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх чиглэлээр сумын Онцгой комисст албан бичгээр чиглэл хүргүүлэх,


Сумын Засаг дарга, Онцгой комиссын
дарга нарт:

4.4.Аймаг, сумын Онцгой комиссын шийдвэрээр томилогдон ажиллаж буй албан хаагч нарт галын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх чиглэлээр үүрэг чиглэл өгч ажиллах,

Тав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.1.Коронавируст халдвар "Ковид-19"-тай тэмцэх ажилд үр бүтээлтэй ажилласан Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмч, ажилчдыг урамшуулахад шаардагдах зардал 4,0 сая төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас Бүсийн оношлогоо эмчилгээний төвд олгох,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
Цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн, хурандаа Б.Бямбаа,


/ М.Бадамсүрэн
/ х/ч Б.Цогтбаяр

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа нарт:

5.2.Коронавируст халдвар "Ковид-19"-тай тэмцэх ажилд салбар бүрээс үр бүтээлтэй ажилласан албан хаагчдын судалгааг гаргаж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА  М.БАДАМСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ  Б.ЦОГТБАЯР

